

2015.05.01-ноос 2015.05.29-ны өдрийн хооронд ирсэн мэдээлэл, түүний шийдвэрлэлт

No	Огноо			Товч утга	Шилжүүлсэн байдал		шалгасан байцаагч	Шийдвэрлэсэн байдал
		Иргэн	Нэр		Аль нэгжийн хэнд	Огноо		Хэрхэн шийдвэрлэсэн
1	2015.07.03	Иргэн	Бэхболд	Сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүргийн нисэх орчимд хүн оршин суух ямарч боломжгүй болж байна. Бохир агаартай, тоос шороо дэндүү ихтэй байна. Иймд энэ асуудлыг яаралтай шалгаж арга хэмжээ авч өгнө үү.	ХУД-ийн МХХ	2015.07.03	ХУД-ийн МХХ	Иргэний ирүүлсэн гомдлын дагуу Нийслэлийн агаарын чанарын албанаас авсан шинжилгээнээс үзэхэд: Агаар дахь хүхрийн давхаршил, азотын давхаршил стандарт нормоос хэтрээд, агаар дах тоосонцорын хэмжээ мөн адил стандартаас хэтрээд байна. Мөн нисэх орчимд бохир халиад байна. Дээрх асуудлын талаар анхааралдаа авч ажиллах талаар хорооны Засаг дарга болон ХУД-ийн Засаг даргад шуурхай хуралд мэдээлэл өгч ажилласан. Иргэн Бэхболдод утсаар хариу хэлсэн.
2	2015.07.03	Иргэн	Мөнхцэцэг	БЗД-ийн 21-р хороо Дарь эхийн шинэ буудлын шинэ хүнс дэлгүүрийн урьд талын нийтийн халуун усанд нохой оруулж байсан бөгөөд манай хүүхдийг гэмтээсэн нь цагдаа дээр шалгагдаж байна. Халуун усанд нохой оруулж болдог талаар шалгаж хариу өгнө үү.	БЗД-ийн МХХ	2015.07.03	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Э.Ариунболд	Тухайн гомдлыг шалгах хяналтын хуудас байхгүй тул хяналт шалгалт хийх боломжгүй. Нохой хүүхэд гэмтээсэн тул хуулийн байгууллагаар шийдүүлэх нь зүйтэй.
4	2015.07.03	Иргэн	Амартайван	Чингэлтэй дүүрэгт нохой үржүүлгийн газар /100 гаруй нохойтой/ байгуулсан байна. Гэтэл зүүн салаанд 2 үхэртэй айл байж болохгүй гэж МХГ-аас хөөж байгаа нь ямар учиртай вэ? Шалгаж хариу өгнө үү.	СХД-ийн МХХ	2015.07.03	Мал амьтан хорио цээр, чанарын хяналтын улсын байцаагч С.Сэргэлэн	Гомдол гаргагч иргэний утасны дугаар буруу /96668797 тоот утсаар холбогдоход аавруу холбогд гэсэн боловч аав нь гомдол гаргаагүй БЗД-т амьдардаг иргэн гэсэн тул/ хаяг тодорхойгүй байгаа тул хяналт шалгалт хийх боломжгүй байна.

3	2015.07.06	Иргэн	Цэцгээ	19-р хороо Шадивлан нэртэй газарт мал бэлчээд иргэдэд хүндрэл учруулж байна	ЧД-ийн МХХ	2015.07.06	Улсын байцаагч Д.Пүрэвсүрэн	2015.07.08-ны өдрийн 11.00 цагт гомдлын дагуу ЧД-ийн МХХ-ийн мал амьтан, хорио цээр чанарын хяналтын улсын байцаагч Д.Пүрэвсүрэн хяналт шалгалтын гүйцэтгэлээ. Шалгалтаар ЧД-ийн 19-р хороо Шадивлан зуслангийн голын баруун талд буусан малтай айл байхгүй байлаа. Голын зүүн талд 2 унага уясан зэл татсан байсан тул гомдол гаргасан харъяа дүүргийн холбогдох газарт хандахыг зөвлөв. Гомдол гаргасан иргэнд зураг авч баримтжуулж, амаар биечлэн хариу өгөв.
4	2015.07.06	Иргэн	Нарандэлгэр	Баянзүрх дүүргийн 14-р хороо 201-р байрны хажууд Мон-Консулт барилгын кампани зөвшөрөлгүй газар ухаж, стандарт зөрчиж цэвэр усны шугам дайруулан, ултаар хөрсний нуралт үүсэж иргэд оршин суугчдын амьдрах орчинд хүндээр нөлөөлж байгаа тул арга хэмжээ авна уу.	НМХГ	2015.07.06		
5	2015.07.06	Иргэн	Эрдэнэсүвд	Сүхбаатар дүүрэгт 40-Мянгатад байрлах "Алтан гадас" хоолны газарт шөнийн цагаар насанд хүрээгүй хүмүүст архи худалдаалж байгаа хууль бус үйлдлийг шалгаж өгнө үү.	СБД-ийн МХХ	2015.07.06	Хэлтсийн дарга М.Цэндсүрэн	Иргэн н. Эрдэнэсүвдн "Алтан гадас" хоолны газар шөнийн цагаар архи худалдаалаад байгаа асуудлаар өгсөн гомдлыг буцааж байна. МХЕГ-ын даргын 177 тоот тушаалын дагуу цагдаагийн байгууллага цаг хэтрэлт шөнийн цагаар архи борлуулаад байгаад хяналт тавина.
6	2015.07.06	Иргэн	Цагаанхүү	Сүхбаатар дүүргийн 1-р төрхийн хажууд байрны "Нахиа" хоолны газарт муудсан махаар хийсэн хоолоор үйлчилж байна. Энэ талаар арга хэмжээ авч өгнө үү.	СБД-ийн МХХ	2015.07.06	ХЧАБХ-ын улсын байцаагч Б.Цэрэндулам	Гомдлын дагуу хяналт шалгалт хийж, зөрчлийг газар дээр нь арилгуулж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Гомдол гаргасан иргэнд утсаар хариу мэдэгдэхээр залгалат утас нь холбогдох боломжгүй байв.

7	2015.07.06	Иргэн	Төмөрбаатар	Сүхбаатар дүүрэгт байрлах "Алтангас" хоолны газарт шөнийн цагаар архи худалдаалж удаа дараа агсам согтуу тавьж хууль бус үйлдэл гаргаж байна. Хариуцсан дүүргийн цагдаа нь ажлаа хариуцлагатай хийж байга уу? Үүнийг хянаж шалгаж өгнө үү.	СБД-ийн МХХ	2015.07.06	Хэлтсийн дарга М.Цэндсүрэн	Иргэн Төмөрбаатарын "Алтан гадас" хоолны газар шөнийн цагаар архи худалдаалаад байгаа асуудлаар өгсөн гомдлыг буцааж байна. МХЕГ-ын даргын 177 тоот тушаалын дагуу цагдаагийн байгууллага цаг хэтрэлт шөнийн цагаар архи борлуулаад байгаад хяналт тавина.
8	2015.07.06	Иргэн	Батмагнай	Баянгол дүүрэгт Аркын эсрэг талд байрладаг "Ван жау" хятад хоолны газарт хоолноос нь ялаа гарсан тул холбогдох арга хэмжээ авна уу.	БГД-ийн МХХ	2015.07.06	ХЧАБХУБ Б.Хонгор	Гомдол гаргач иргэн Батмагнайтай утсаар холбогдоход тухайн үед үйл ойлголцол үүссэн байсан учраас өөрийн хүсэлтээр гомдолоо хаахаар болсон тул гомдлыг хаав
9	2015.07.06	Иргэн	Солонго	Сонгинохайрхан дүүргийн Энх-Эрдэнэ сувиллын газрын хажууд байранд үйл ажиллагаа явуулдаг Хэрчсэн гурилын цех Шөнийн цагаар хууль бусаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнийг шалгаж өгнө үү.	МХЕГ	2015.07.06	МХЕГ	Иргэн утсаа өгөөгүй тул гомдлыг шалгах боломжгүй учраас гомдлыг хаав.
10	2015.07.06	Иргэн		Нарантуул захаас худалдаж авсан цагаан будаа үйрч бутраад байна. Огт өсөхгүй цагаан үйрмэг зүйл болоод байна. Энэ талаар арга хэмжээ авч өгнө үү.	МХЕГ	2015.07.06	МХЕГ	Хүсэлт гаргасан иргэний нэр, хаяг тодорхойгүй тул хаав.
11	2015.07.07	Иргэн	Монголмаа	Баянзүрх дүүргийн 2-р хороонд байрладаг эмийн сан хууль бусаар үйлчилгээ явуулж байна. Урд нь мэдүүлж байсан ч дахин арга хэмжээ авах шаардлагатай байна.	БЗД-ийн МХХ	2015.07.07	Эмбиобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Э.Одонтуяа	Тус гомдлын дагуу шалгалт хийж үйл ажиллагааг түр зогсоож тусгай зөвшөөрөлд заасан хаягаас өөр газарт үйл ажиллагаа явуулж байсан тул улсын байцаагчийн акт тавьж албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ ногдуулсан болно.
12	2015.07.07	Иргэн	Батбаяр	Баянхонгор аймгийн Жаргалант суманд Сүүлийн 10 хоногийн турш уул уурхайн хаяг нь тодорхойгүй том машинууд Байдрагийн голд бохир ус нийлүүлж дур мэдэн далан нуур үүсгэж үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнийг шалгаж, арга хэмжээ авч өгнө үү.	БОГУУХГ	2015.07.07	Улсын байцаагч С.Нямжав	Баянхонгор аймгийн МХГ-ын БО-ны хяналтын улсын байцаагчтай утсаар ярьж хяналт шалгалт хийлгэж, тухайн уул уурхайн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож, хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Мөн энэ талаар гомдол гаргасан иргэнд утсаар мэдэгдэж ажиллахыг аймгийн МХГ-т үүрэг болгов.

13	2015.07.08	Иргэн	Оюунчимэг	Хархорин захын дайвар бүтээгдэхүүн зарж байгаа хэсэгт ялаа, батгана шавсан, үнэр танар муухай юм зарж байна. Хэлэхээр хүлээж авахгүй байна. Яаралтай ирж шалгаж өгөөч	БГД-ийн МХХ	2015.07.08	Мал эмнэлэгийн хяналтын улсын ахлах байцаагч Ч.Саруултуяа	"Хар Хорин" худалдааны төвд худалдаалагдаж буй малын гаралтай дайвар бүтээгдэхүүнд тус төвийн дэргэдэх МЭАЦ-ийн лабораторын эрхлэгч Б.Цогзолмаа, шинжлэгч эмч С.Уранчимэгийг байлцуулан холбогдох улсын байцаагчтай хамтран 2015.07.09-ний өдөр хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан. Иргэн Оюунчимэгт утсаар хариу мэдэгдсэн.
14	2015.07.08	Иргэн	Энхцэцэг	Хөвсгөл аймгийн Мэргэжлийн Хяналтын газрын дарга саяхан зохион байгуулсан арга хэмжээний зардал нэрийдлээр ажилчдаас 90,000төгрөг нэхэж, мөн Unitel-ийн дараа төлбөрт дугаар ав гэж шаардаж, зүй бус үйлдэл гаргаж байгааг арга хэмжээ авч өгөөчээ. Манай дүү энэ байгууллагад ажилладаг өөрөө байнга л ажил дээр тийм асуудалтай байна гэж хэлдэг би иргэний хувьд ийм зүйл байж болдог юм уу, тодруулж өгөөчээ болиулж сануулахыг хүсэж байна.	ТЗУГ	2015.07.08	Улсын ахлах байцаагч Л.Энхбаяр	Ирүүлсэн гомдлыг шалгах зорилгоор гомдол гаргасан иргэний 95386474 дугаарын утсаар ярихад энэ утсан дээр Энхцэцэг гэж хүн байхгүй танай байгууллагад гомдол гаргаагүй гэсэн учраас гомдлыг хаав.
15	2015.07.09	Иргэн	Дугарсүрэн	Төв цэнгэлдэхийн ойролцоо наадмын хуушуур хийж худалдаалдаг аж ахуй нэгжүүд наадмын сүүлийн өдөр буюу 7.12-ны орой тарахдаа хуушуур хайрсан тосоо явган хүний зам, модны ёроол, зүлэгрүү шууд асгадаг. Удаа дараа олон жил ийм байдлыг ажиглаж байна. Цэнгэлдэхийн хажууд амьдардаг хүний хувьд баярын дараа маш их тос болсон бохир орчин үлддэг нь оршин суугчдад хүндрэлтэй байдаг. Тиймээс энэ хэсгийг хариуцдаг МХ-н байцаагч нар нь тэдгээр хүмүүст өмнө нь сайтар сануулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваасай гэж хүсэж байна.	ЭМБСХГ	2015.07.09	Улсын ахлах байцаагч Ч.Гантулга	МХЕГ-ын даргын 1/164 тоот удирдамж, НМХГ-ын даргын А/41 тоот удирдамжийн хүрээнд төв Цэнгэлдэх газрын орчимд худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ рэхлэх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа. Ажиллах явцдаа иргэнээс ирүүлсэн мэдээлэл, саналыг тусган холбогдох аж ахуйн нэгжүүдэд үүрэг өгч ажилласны дүнд хуушуур хайрсан тосоо бохир усны цооногт хаяж орчны бохирдлыг багасгасан. Утсаар иргэнд хариуг өгч ажилласан.
16	2015.07.10	Иргэн		Гандангийн автобусны хажууд байрладаг Тосол маслын түц хажуудаа дугуй засвартай тэнд масло тосолоо байнга хулхи хуурамч бараа зарж байна. Үүнийг шалгаж өгнө үү.				

17	2015.07.10	Иргэн	Бор	Дорноговь аймгийн Улаанбадрах сум баянбогд багт Малнууд 2015-оны 7-р сарын 9 өөс эхэлж 2-3 мал үхээд байна. Энд Ураны “овь ХХК” нэртэй компани зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулдаг юм байна энийг яаралтай шалгаж арга хэмжээ авч өгнө үү.	ХХААХГ	2015.07.10	Улсын ахлах байцаагч Ганхуяг	Дорноговь аймгийн Байгаль орчны нийгэмлэгт ажилтай Бортой 2015.07.16-ны өдрийн 8.00 цагт утсаар холбогдож лавлахад Кожеговь компаний зөвшөөрөлтэй эсэхийг шалгаж өгөх талаар цөмийн энергийн хяналтын газарт хандсан юм: Мал үхээд байгаа шалтгааныг мэргэжлийн байгууллагууд газар дээр нь үзэх шаардлага байна гэсэн. 4-р сард Японы судалгаа шинжилгээний эрдэмтэд шинжилгээ хийхэд зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү байна. Доктор Цэрэнчимэд үхсэн малд ураны хэмжээ илүү гарсан гэсэн дүгнэлтүүд гарсан юмаа гэж мэдээлэл хийв.
18	2015.07.16	Иргэн	Нансалмаа	Баянгол дүүрэгт байрладаг Вокзалын хажууд “Баялаг” гэх газарт муудсан махаар хоол хийж иргэдэд үйлчилж байна. Муудсан махаар хийсэн хоолыг нь аваад хадгалсан байна. Яаралтай энийг шийдэж эргээд холбоо барина уу. Дүүргийх нь мэргэжлийн хяналт утсаа огт авахгүй байна. Энийг яаралтай одоо газар дээр нь шалгаж өгнө үү.	БГД-ийн МХХ	2015.07.16	Улсын байцаагч Л.Энхцэцэг	Гомдлын дагуу хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 27-03-242/222 тоот албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, Гомдол гаргагч иргэн Нансалмаад 88021522 дугаарын утсаар хариу өгч ажиллалаа.
19	2015.07.16	Иргэн	Лхагвасүрэн	Хан-Уул дүүрэгт байрладаг Апу-ийн хажуудах “Номин” супермаркетаас Өнөөдөр Сир авсан муудсан хөгзөрсөн байсан. Энийг яаралтай мэдэгдэж эргэж хариу өгнө үү.	ХУД-ийн МХХ	2015.07.16	Улсын байцаагч Р.Нармандах	Номин агуулах Хайпермаркетэд худалдаалж байгаа Герман улсаас импортлосон Велами нэрийн сирнээс дээж авч НМХГ-ын лабораторит шинжлүүлэхэд А293 тоот сорилтын дүнгээр хөгц илрээгүй байна. Утсаар хариу өгсөн.
20	2015.07.16	Иргэн	Доржсүрэн	Сонгинохайрхан дүүргийн 24-р хороонд “Бумбат” рашааны дэргэд 50м-н зайтай 2 түц байрлуулж хог бохироо ил задгай асгаж бохирдуулж байгаа тул энэ 2 түцийг эндээс нүүлгэж өгнө үү.	СХД-ийн МХХ	2015.07.16	Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ба.Энхцэцэг, А.Мөнх-эрдэнэ	Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу холбогдох улсын байцаагчидтай хамтран хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн 02-03-390/46, 47 тоот үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай актаар тус 2 хуушуурын цайны газрын үйл ажиллагааг зогсоолоо.

21	2015.07.17	Иргэн	Сугардалай	Хуучин бөмбөгөрийн 1 давхарт байрладаг буфет-ээс 2 ширхэг хуушуур өчигдөр авсан. Муудсан махаар хийсэн хуушуурнаас нь маргааш нь хордлого өгөөд босч чадахгүй байна. Энийг шалгаж өгөөчээ. Чанарын шаардлага хангасан хоол зарж байна уу. Шалгаж арга хэмжээ авч өгнө үү.	ЧД-ийн МХХ	2015.07.17	Улсын байцаагч Д.Лхамсүрэн, Б.Насанжаргал	Иргэн Сугардалайтай холбогдож асуухад хуушуурнаас шалгалтаагүй өөр хоол хүнснээс болж гэдэс хямарсан гэсэн тул гомдлыг хаав.
22	2015.07.20	Иргэн	Хүрэлбаатар	Сонгинохайрхан дүүрэгт байрладаг "Туул" нэртэй хоолны газраас яг одоо хоол авч идээд үйлчлүүлж байна. 2 ширхэг хуушуур авсан мах нь улаан өнгөтэй хоносон юмуу эсвэл муудсан мах байна гэтэл урдаас авч шидээд шинэ мах гэж дайраад байх юм. Энийг шалгаж өгнө үү.	СХД-ийн МХХ	2015.07.20	Улсын байцаагч Ба.Энхцэцэг, Г.Билгүүн	Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу холбогдох улсын байцаагчидтай хамтран хяналт шалгалт хийж, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагч байцаагчийн 02-03-390/284 тоот албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, МУ-ын "Захиргааны хариуцлагын тухай" хуулийн 52,5 дах заалтыг үндэслэн 25000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.
23	2015.07.22	Иргэн	Зоригтбаатар	Чингэлтэй дүүргийн "Салхит Ар согоот" гэдэг газарт үйл ажиллагаа явуулдаг Эсгийний үйлдвэр нь эсгий угаасан усаа бороо ороход мөн ил задгайгаар гудамжруу асгаад байна. Маш муухай үнэртэй ус тэр хавь ойроор нэг болсон. Хүүхдүүд тэр усаар нь тоглоод, дотроос нь өт хорхой хүртэл гарсан. Гудмаар дүүрэн өмхий шавар шалбааг хүн бүү хэл машин ч явахад хэцүү байдалтай байна. Тухайн байгууллагад нь орж хэлж үзсэн авч хэлцэхгүй тоож байгаа ч юм алга. Энэнд яаралтай арга хэмжээ авч шалгаж өгнө үү.	ЧД-ийн МХХ	2015.07.22	Улсын байцаагч Г.Цэцэгдэлгэр	Гомдлыг 2015.07.22-ны өдөр шалгаж, 33-03-412/198 тоот албан шаардлага хүргүүлж, иргэнд утсаар мэдэгдэв. Гүйцэтгэлийг 2015.07.25-ны өдөр шалгана.

24	2015.07.23	Иргэн	Сарантуяа	Баянзүрх дүүрэгт байрладаг “Баянзүрх Зах”-ын хажууд оршин суудаг хүн байна. Энэ захын эргэн тойрон үнэхээр маш бохир эрүүл ахуйн ямарч шаардлага хангасан зүйл огт алга байна. Жишээ нь гэхэд зах хаасны дараа өглөө энэ хавь үнэхээр заваан бохир хүмүүсийн хаясан хог, шээс баас булан тохой нь хүн хажуугаар нь өнгөрөх ч арга алга мөн иргэд захын гадна машин дотроосоо ил задгай хувцас, хүнсний бүтээгдэхүүн жимс, ногоо зарж байна. Баталгаатай эрүүл ахуйн шаардлага хангасан бараа зараад байна уу. Мөн энэ хавиар ямар ч хот тохижилт шийдсэн асуудал алга машин хүн нь багтаж ядсан хүн явах зам бараг байхгүй битүү наймаачид машин хог шороо байна. Энд эрүүл ахуйн шалгалт хийж арга хэмжээ авч өгнө үү.	БЗД-ийн МХХ	2015.07.23	Хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Б.Цэрэндулам	Гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд тус захын орчин тойрон бохир цэвэрлэгээ хангалтгүй байсан тул чиг үүрэг өгөх тухай 2015.07.31-ний 11/177 тоот албан бичиг хүргүүлэв. Гомдол гаргасан иргэн н.Сарантуяад утсаар хариу мэдээлэв.
25	2015.07.23	Иргэн	Зориг	Чингэлтэй дүүрэг 17 дугаар хороо хуучин эцэст Хаан банктай байр, 2 давхарт нь эмийн сан ажилладаг. Эмийн сангийн үүдэнд үсчин ажиллаад үсчний бүх үнэр эмэнд шингэж, эмийн чанарт нөлөөлж байна. Энэ асуудлыг шалгаж өгнө үү.	ЧД-ийн МХХ	2015.07.23	ЧД-ийн МХХ	Гомдол гаргасан иргэний 99185029 дугаарын утсаар холбогдотол ийм гомдол өгөөгүй гэсэн тул хаав.
26	2015.07.23	Иргэн	Тэрбиш	Чингэлтэй дүүргийн 1-р хороо Явуухулангийн цэцэрлэгийн чанх урд байрладаг “Times national news” байгууллага нь төвлөрсөн цахилгаан дамжуулах цэгтэй метр ч хүрэхгүй маш ойрхон байрлаж барилгаа барьснаас болж тог массаад хажуудах байрны айлууд болон тэр хавь тоггүй болдог. Энэ барилга нь ашиглалтанд ороогүй байж нууцаар ажиллаж байдаг юм энийг шалгаж өгөөчээ. Залгуулаад барьнаас болж үргэлж тог тасраад байгаа тул энэ байгаа тул энэ байгууллагад нь холбож арга хэмжээ авч өгнө үү.	НМХГ	2015.07.23		
27	2015.07.24	Иргэн	Энххишиг	Баянзүрх дүүрэг Нарны зам дагуу байрладаг “Миний хайпермаркет” дэлгүүр байнга гашилсан сүү зарах юм олон удаа орж хэлсэн тоож байгаа юм алга энийг шалгаад арга хэмжээ авч өгнө үү.	БЗД-ийн МХХ	2015.07.24	Хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Б.Цэрэндулам	2015 оны 07 дугаар сарын 28-нд гомдол гаргасан иргэн н.Энх-хишигээс ирүүлсэн гомдлын дагуу гашилсан сүү худалдаалж байсныг нотлох баримт байгаа эсэхийг шалгахад байхгүй байсан тул уг гомдлыг үндэслэлгүй гэж үзэж иргэнд хариу мэдээлэв.

28	2015.07.27	Иргэн	Түвшинбаатар	Баянхонгор аймгийн мэргэжлийн хяналтын байцаагч Мөнхбат нь наадмын өмнө хлорамин бодисыг 1 шуудайг нь 70.000 төгрөгөөр шахаж зарсан, аваагүй хүнийг шалгана гэж дарамталж байгааг шалгаж өгнө үү. Иргэн нэр хаягаа нууцлахыг хүссэн байна.	ХШУДАХ	2015.07.27	Улсын байцаагч Болормаа	Иргэн Түвшинбаатарт /88066806/ аймгийн МХГ нь "Эрүүл хүнс, Эрүүл хөрс" сарын аяны хүрээнд хлораминыг айл өрхөд үнэ төлбөргүй, ААНБ-д кг-ийг нь 3000 төгрөгөөр өгч ойр орчмын хөрсийг ариутгах зорилгоор Засаг даргын захирамж гаргуулж ажилласан байна. Үүний дагуу танай компанид очин ариутгалын бодис тараасан талаар утсаар холбогдон хэлж ойлгуулав.
29	2015.07.28	Иргэн	Б.Отгонсүрэн	СБД-ийн 16-р хороонд 240 хүүхдийн цэцэрлэг ган худгийн буудал дээр баригдсан цэцэрлэгийн дээврийн ус зайлуулах хоолойг буруу байрлуулсан ус нь айлын хашаа руу гоождог асуудлыг шалгаж арга хэмжээ авч өгнө үү.	МХЕГ	2015.07.28	МХЕГ	Иргэн холбоо барих утас, хаягаа хэлээгүй тул шалгах боломжгүй. Иймд гомдлыг хаав.
30	2015.07.28	Иргэн	Т.Цолмон	ХУД-ийн рапит харшид байрлах Аксис хоолны газарт хоол идсэн 103 дуудаж арга хэмжээ авагдсан хоолны хордлого гэж оношлогдсон. Шалгаж өгнө үү.	ХУД-ийн МХХ	2015.07.28	Улсын байцаагч Б.Дагийранз	Иргэн Т.Цолмонтой холбогдож хоолны хордлого нь 2 ба түүнээс дээш хүн нэгэн зэрэг өвдсөн тохиолдолд хордлого гэж оношлодог ба энэ тохиолдол нь хоолны хордлого биш гэдэсний чочмог хямрал гэж үзэж байгаа талаар мэдэгдсэн.
31	2015.07.28	Иргэн	Төмөрхуяг	Орхон аймгийн Яргуйт багт хатгадаг, хандаг хүн ирээд 10-аад хоног ажиллаж байна. Энэ нь халдвар тараах эрсдэлтэй байна. Тухайлбал В, С вирус, ДОХ халдах магадлалтай байна. Энийг шалгах хэрэгтэй байна. Орхон аймагт мэдэхгүй хүн алга. Энэ хүн Малын эмч гэсэн.	ЭМБСХГ	2015.07.28	Улсын ахлах байцаагч Н.Долгорсүрэн	Орхон аймгийн МХХ-ийн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч О.Оюунтунгалагтай холбогдож асуудлыг шалгуулахад 7.23-нд Цагдаагийн байгууллага шалган гэж буцаасан байна. Иргэнтэй холбогдож хариу өгсөн.
32	2015.07.28	Иргэн	Отгончимэг	Барс 2-н үүдэнд самар өндөг зараад байна. Шалгаж өгнө үү.	БГД-ийн МХХ	2015.07.28	ХЧАБХУБ Д.Саруул, Л.Энхцэцэг	Гомдлын дагуу хэлтсийн даргын удирдамжаар хамтарсан хяналт шалгалт хийлээ. Барс -2 худалдааны төвийн үүд орчмоор болон гадна талбайд чанасан өндөг самар зарж байсан зөрчил илэрсэнгүй. Гомдол гаргагчид байдлыг утсаар танилцуулж зохих нотлох баримтын хамт өргөдөл гомдол гаргаж байхыг зөвлөв. Төвийн удирдлагуудад сэрэмжлүүлэг зөвлөгөө өгч ажиллав.

